



ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БАТЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.28. № 3/306
Аудитын гэрчилгээ

танай _____-ны № _____-т

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Үндэсний дата төв УТУГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний дата төв УТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0223SAG10.Docx

У/А/0122

073327



ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын Тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн Аудитын Газрын дарга
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг Утас: 261663
Цахим
хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахим хаяг: batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний дата төв УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.УАГ-САГ/2017/1/СТА-УТҮГ/

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд хийхээр төлөвлөж хэрэгжүүлэв.

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дугаар сарын 30-нд 01/53 тоот албан бичгээр аудитад ирүүлсэн болно.

Аудитыг 2016 оны 10 дугаар сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 18-нд Үндэсний аудитын газарт хүлээлгэж өгөв.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Шилэн дансны тухай”, “Хувь хүний орлогын албан татварын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, заавартөөрчлөлт ороогүйбайна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны бдугаар сарын 24-ний өдрийн 183 тоот тогтоолоор “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар (УТҮГ)-ыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын дэргэд байгуулсан. Үндэсний дата төв УТҮГ-ын эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын үндэсний цахим дата, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ юм.

Үндэсний дата төв УТҮГ-ын дүрмэнд тусгаснаар тус байгууллагын үндсэн зорилго нь өөрийн үйл ажиллагааг тогтвортой, найдвартай, тасралтгүй хэрэгжүүлж, Монгол Улсын Үндэсний цахим дата, мэдээллийн нэгдмэл, шуурхай хүртээмжтэй байдлыг хангахад оршино.

Монгол Улсын Засгийн газраас “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлуудыг 2007 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд тус байгууллага нь төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, хөтөлбөрийн хүрээнд суурь дэд бүтцийг байгуулан ажиллаж байна. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сонгуулийн автомат тооллогын систем, ТҮЦ машин, Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн систем, Камерийн торгуулийн систем, Цахим татварын систем, Цахим тендер, Цахим виз, Албан журмын даатгал зэрэг улс орны хэмжээнд цахим хэлбэрээр хийгддэг үйлчилгээнүүдийг хариуцан ажиллаж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Тус байгууллага нь 2016 онд нийт 5 хэлтэс, 68 ажиллагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд холбогдох хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маяганд тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн

тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилуудыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Үндэсний дата төв УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан Үндэсний дата төв УТҮГ-ын захирлын 2011 оны 91 тоот тушаалаар батлуулан, батлагдсан хугацаанаас эхлэн мөрдөнөжиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичигт Нягтлан бодох бүртгэлийн хуулийн шинэчилсэн өөрчлөлтийн дагуу Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” тушаал болон “үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах норм тогтоох” зэрэг өөрчлөлтийг тусгаагүй. Мөн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй сүлжээний тоног төхөөрөмжүүд нь нэг багц байдлаар үнэлэгдэж бүртгэгдсэн. Гэтэл тухайн тоног төхөөрөмж нь олон тооны жижиг эд ангиудаас бүрдсэн байдаг ба эвдэрч гэмтсэн тохиолдолд сольдог. Эдгээр хөрөнгийг эд анги тус бүрээр нь салгаж бүртгээгүйгээс сольсон эд ангийн өртгийг данснаас хасах болон капиталжуулах (мөн урсгал зардлаас худалдан авч байгаа тул хөрөнгөөр бүртгэх боломжгүй) боломжгүй тул тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг ба энэ онцлогийг бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгах шаардлагатай байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Үндэсний дата төв УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуусанхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд Үндэсний дата төв УТҮГ-ын материаллаг байдлын түвшинг тогтоохдоо нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон сонгох нь тохиромжтой гэж үзэв. Төлөвлөлтийн үе шатанд нийт зардал, орлого, цэвэр хөрөнгийг суурь үзүүлэлт болгон материаллаг байдлын түвшинг тооцоход эдгээр үзүүлэлтээс тооцсон түвшин нь хэт бага байгаа тул нийт хөрөнгийг материаллаг түвшний үнэлгээнд суурь үзүүлэлт болгохоор сонгосон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ. Тус байгууллагын санхүүгийн тайлангийн материаллаг байдлын түвшинг нийт хөрөнгийн 1 хувиар буюу 78.1 сая төгрөг гэж тодорхойлов. /ТАБ-СТА-А-4/. Агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг аливаа зүйл байхгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ

нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Үндэсний дата төв УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавинажилласан байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,762.7сая төгрөгийн санхүүжилт авч, 1,653.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, 5.9 сая төгрөгийнбусад орлого, нийт 3,422.3 сая төгрөгийн орлого олж 2,941.1 сая төгрөгийн зардал гаргаж 152.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 321.0 сая төгрөгийг төсвийн захирагч хооронд шилжүүлжээ.

Урсгал зардалд 2,954.5сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,941.1сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг13.4сая төгрөгөөр дутуу зарцуулсанбайна. Батлагдсан төсвийн зардлыг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй боловч зардлын зүйл анги хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл:

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын жилийн батлагдсан төсөв, сар улирлын төсвийн хуваарь төсөв , гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ зэрэг санхүүгийн мэдээллүүдийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд тогтмол оруулж тайлагнаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, орлого, цалин хөлсний зардал, гэрэл цахилгааны зардал, түлш, халаалтын зардал, байрны түрээсийн зардал, бичиг хэргийн зардал, тээвэр, шатахууны зардал, шуудан холбооны зардал, урсгал засварын зардал, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал, холбооны суваг ашигласны зардал, гадаад томилолтын зардалзэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 30.2хувь, мөнгөн хөрөнгийн 69.3 хувь, нийт бараа материалын 42.0 хувь, нийт зардлын65.2хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтанд хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараахалдаа илэрсэн байна. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 168 нэр төрлийн 4,676.7 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСННБОУС 17 “хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт”-тэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн шинээр тогтоож дахин үнэлж бүртгэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Үндэсний дата төв УТҮГ нь ҮДТ-2016/001 дугаартай Халаалтын бойлерт хэрэглэх түлш нийлүүлэх-багц1, автомашинд хэрэглэх шатахуун нийлүүлэх- багц 2 нээлттэй тендер зарласан. Тус тендерт Магнай трейд ХХК шалгарсан байна. Дээрх ДҮТ-2016/001 дугаар бүхий нээлттэй тендерийн үйл ажиллагааг явуулахдаа e-procurement.mn сайт болон өдөр тутмын сонинд зар нийтлээгүй, тендерийн үр дүнг e-procurement.mn сайтад мэдээлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ", 21.4 "Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байршуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ" заалттай нийцэхгүй байна. Мөн Магнай трейд ХХК гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байгаа нь гэрээний тусгай нөхцөл 5-д" Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бараа материалын дансанд нийт 111.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 12, УСНББОУС 17 болон Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” журамтай нийцэхгүй байна. Шалтгааныг тодруулахад Үндэсний дата төв УТҮГ нь өмнөх жилүүдэд хөрөнгө оруулалтын зардал төсөвлөөгүй бөгөөд төсвийн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн тул уг бэлтгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг Төрийн өмчийн хороо зөвшөөрөөгүй, иймээс бараа материалд ангилж бүртгэсэн гэсэн тайлбар өгсөн.

Шийдвэрлэсэн: Бараа материал ба үндсэн хөрөнгийн ангиллын талаар эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж залруулж бүртгэх, хөрөнгө ба бараа

материалыг УСНББОУС болон Сангийн Сайдын баталсан “төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” журмын дагуу зөв ангилж тайлагнаж байх, хөрөнгө ба бараа материалын ангилал ба шалгуур үзүүлэлтийн талаар байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхой заалт оруулах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтхууль, дүрэм журмын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохироогүйбайгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тухайлбал: нягтлан бодох бүртгэлдсүлжээний тоног төхөөрөмжүүдийг нэг багц байдлаар үнэлж бүртгэсэн. Гэтэл тухайн тоног төхөөрөмж нь олон тооны жижиг эд ангиудаас бүрдсэн байдаг ба эвдэрч гэмтсэн тохиолдолд сольдог. Эдгээр хөрөнгийг эд анги тус бүрээр нь салгаж бүртгээгүйгээс сольсон эд ангийн өртгийг данснаас хасах болон капиталжуулахболомжгүй тул тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж байна.

Шийдвэрлэсэн:Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг стандарт, холбогдох хууль эрх зүйн дагуу боловсруулж, мөрдлөгө болгох талаар зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитаар дээрх зөрчилтэй асуудлуудад зөвлөмж өгсөн бөгөөдҮндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Үндэсний дата төв УТҮГ-ын халаалтын бойлер, цахилгаан үүсгэгч генераторт зарцуулсан түлшний зарцуул алтын тооцоог бүрэн гүйцээж мөшгин, шалгаж амжаагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийнтайланд хийсэн аудитаар нийт 4,874.2сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4,854.6сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 19.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгсөнөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний дата төв УТҮГ-ын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 11хуудсыгхавсаргав.



ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Үндсэн хөрөнгийн талаар

Асуудал 2
Худалдан авалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Бараа материалын талаар

Асуудал 2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичгийн талаар

2016оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Үндэсний дата төв УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бэлтгэсэн бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндэсний дата төв УТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1:**Тэргүүлэх ач холбогдол №1****Үндсэн хөрөнгийн талаар****Ажиглалт**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 168 нэр төрлийн 4,676.7 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСННБОУС 17 “хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт”-тэй нийцэхгүй байна.

Зөвлөмж

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн шинээр тогтоож дахин үнэлж бүртгэх.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, стандарт болон заавар журам зөрчигдөх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Худалдан авалтын талаар**Ажиглалт**

Үндэсний дата төв УТҮГнь ҮДТ-2016/001 дугаартай Халаалтын бойлерт хэрэглэх түлш нийлүүлэх-багц1, автомашинд хэрэглэх шатахуун нийлүүлэх- багц 2 нээлттэй тендер зарласан. Тус тендерт Магнай трейд ХХК шалгарсан байна. Дээрх ДҮТ-2016/001 дугаар бүхий нээлттэй тендерийн үйл ажиллагааг явуулахдаа e-procurement.mn сайт болон өдөр тутмын сонинд зар нийтлээгүй, тендерийн үр дүнг e-procurement.mn сайтад мэдээлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ", 21.4 "Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байршуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ" заалттай нийцэхгүй байна. Мөн Магнай трейд ХХК гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байгаа нь гэрээний тусгай нөхцөл 5-д" Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх,

Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэсэн, бүртгэж тайлагнасан байх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Бараа материалын талаар**Ажиглалт**

Бараа материалын дансанд нийт 111.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 12, УСНББОУС 17 болон Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “төсөвт байгуулагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” журамтай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Бараа материал ба үндсэн хөрөнгийн ангиллын талаар эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж залруулж бүртгэх, хөрөнгө ба бараа материалыг УСНББОУС болон Сангийн Сайдын баталсан “төсөвт байгуулагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” журмын дагуу зөв ангилж тайлагнаж байх, хөрөнгө ба бараа материалын ангилал ба шалгуур үзүүлэлтийн талаар байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхой заалт оруулах.

Эрсдэл

Бараа материал, хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх
Тайлант хугацааны ашиг, алдагдал буруу илэрхийлэгдэх
.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Ажиглалт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтхууль, дүрэм журмын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохироогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тухайлбал: нягтлан бодох бүртгэлдсүлжээний тоног төхөөрөмжүүдийг нэг багц байдлаар үнэлж бүртгэсэн. Гэтэл тухайн тоног төхөөрөмж нь олон тооны жижиг эд ангиудаас бүрдсэн байдаг ба эвдэрч гэмтсэн тохиолдолд сольдог. Эдгээр хөрөнгийг эд анги тус бүрээр нь салгаж бүртгээгүйгээс сольсон эд ангийн өртгийг данснаас хасах болон капиталжуулахболомжгүй тул тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг стандарт, холбогдох хууль эрх зүйн дагуу боловсруулж, мөрдлөгө болгох.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
Удирдлагад буруу мэдээлэл хүрэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	33,000.00	8,224,460.00
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Жижиг мөнгөн сан	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	33,000.00	414,500.00
/гадаад валютаар/	-	-
Богино хугацаат хадгаламж	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	7,809,960.00
<u>АВЛАГА</u>	26,771,499.31	6,630,600.00
Төлбөртэй үйлчилгээний авлага	10,290,000.00	6,630,600.00
Бусад авлага	16,481,499.31	-
<u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u>	-	-
Урьдчилгаа тооцоо	-	-
Урьдчилж гарсан зардал	-	-
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	273,969,943.95	212,846,039.25
Түүхий эд материал	-	-
Хангамжийн материал	-	-
Бичиг хэргийн материал	29,964,848.58	5,303,190.67
Аж ахуйн материал	27,747,886.00	16,991,349.00
Сэлбэг хэрэгсэл	192,434,879.31	174,989,339.58
Түлш, шатах тослох материал	23,822,330.06	15,562,160.00
<u>НӨӨЦИЙН БАРАА</u>		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	300,774,443.26	227,701,099.25
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>		
<u>Биет хөрөнгө</u>	7,618,995,262.55	5,416,896,504.29
Барилга, байгууламж	2,143,735,807.00	2,143,735,807.00
Хуримтлагдсан элэгдэл	(179,219,650.44)	(215,063,580.48)
Авто тээврийн хэрэгсэл	49,500,000.00	49,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(49,498,666.72)	(49,500,000.00)
Машин, тоног төхөөрөмж	13,166,509,763.69	13,211,037,923.69
Хуримтлагдсан элэгдэл	(7,573,479,879.91)	(9,776,958,841.15)
Тавилга, аж ахуйн эд хогшил	135,756,459.71	141,196,159.71
Хуримтлагдсан элэгдэл	(74,385,570.78)	(87,127,964.48)
Номын фонд	77,000.00	77,000.00
Бусад үндсэн хөрөнгө	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Дуусаагүй барилга, байгууламж	-	-
<u>Биет бус хөрөнгө</u>	987,558,299.98	568,317,357.10
Программ хангамж	1,742,649,511.01	1,742,649,511.01
Хуримтлагдсан элэгдэл	(755,091,211.03)	(1,174,332,153.91)
Бусад биет бус хөрөнгө	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
<u>БУСАД ХӨРӨНГӨ</u>		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,606,553,562.53	5,985,213,861.39
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,907,328,005.79	6,212,914,960.64

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
<u>Өглөг</u>	1,064,575.04	15,435,451.11
Ажиллагчидтай холбогдсон өглөг	845,322.98	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	219,252.06	15,435,451.11
Татаас, санхүүжилтийн өглөг	-	-
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	-
Зээлийн хүүгийн өглөг	-	-
Бусад өглөг	-	-
<u>Урьдчилж орсон орлого</u>		
Урьдчилгаа- Төсвийн татаас	-	-
Бусад урьдчилж орсон орлого	-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	1,064,575.04	15,435,451.11
Урт хугацаат зээл	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН		
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,064,575.04	15,435,451.11
Засгийн газрын хувь оролцоо	6,714,633,065.33	6,714,633,065.33
Хуримтлагдсан үр дүн	2,191,630,365.42	(517,153,555.80)
Ємнєх үеийн	5,088,021,895.33	2,191,630,365.42
Тайлант үеийн үр дүн	(2,896,391,529.91)	(2,708,783,921.22)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,906,263,430.75	6,197,479,509.53
ӨР ТӨЛБӨР,ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,907,328,005.79	6,212,914,960.64

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ

		/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	262,495,697.78	228,699,806.98
Төсөвт байгууллагын өөрийн орлого	262,495,697.78	228,699,806.98
Үндсэн үйл ажиллагааны орлого	262,495,697.78	228,332,806.98
Бусад орлого	-	367,000.00
ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,236,014,005.86	2,706,992,990.04
Улсын төсвөөс	1,621,553,848.52	1,610,414,670.49
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,621,553,848.52	1,610,414,670.49
Нэмэлт санхүүжилтийн орлого	614,460,157.34	1,096,578,319.55
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	583,727,618.44	1,096,578,319.55
Төсвийн урамшуулал	30,732,538.90	-
<u>ҮЙЛ АЖИЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН(И)</u>	2,498,509,703.64	2,935,692,797.02
<u>ҮЙЛ АЖИЛАГААНЫ ЗАРДАЛ</u>		
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	5,278,462,531.54	5,644,476,718.24
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1,243,932,263.84	1,332,247,864.70
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,122,176,056.41	1,203,734,703.19
Цалин	1,086,959,056.41	923,542,769.86
Унаа хоолны хөнгөлөлт	35,217,000.00	33,012,000.00
Гэрээт ажлын хөлс	-	247,179,933.33
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимшгэл	121,756,207.43	128,513,161.51
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	99,312,686.30	104,438,467.45
Тэтгэврийн шимтгэл	76,869,165.17	80,363,773.38
Тэтгэмжийн шимтгэл	5,610,880.28	6,018,673.52
ҮОМШӨвчний шимтгэл	11,221,760.56	12,037,347.03
Ажилгүйдлийн шимтгэл	5,610,880.28	6,018,673.52
Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,443,521.13	24,074,694.06
Тогтмол зардал	302,235,492.41	388,836,721.27
Гэрэл цахилгааны зардал	189,427,725.82	252,885,546.43
Түлш, халаалтын зардал	68,037,176.50	63,787,609.06
Цэвэр, бохир усны зардал	7,136,589.80	3,460,440.62
Байрны түрээс	37,634,000.29	68,703,125.16
Хангмж бараа материалын зардал	202,087,572.75	304,292,547.52
Бичиг хэргийн материал	124,839,588.72	174,341,533.28
Тээвэр, шатахууны зардал	53,037,234.00	91,439,170.00
Шуудан холбооны зардал	22,783,505.03	31,798,770.24
Аж ахуйн материалын зардал	1,427,245.00	6,713,074.00
Эд хогшил урсгал засварын зардал	113,063,006.02	351,413,928.73
Урсгал засварын зардал	113,063,006.02	351,413,928.73
Томилолт зочны зардал	26,967,676.00	15,955,000.00
Дотоод томилолтын зардал	-	10,755,000.00

Гадаад томилолтын зардал	26,967,676.00	5,200,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил , үйлчилгээний төлбөр	230,880,224.17	550,575,594.88
Аудитын үйлчилгээний зардал	4,000,000.00	4,500,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний	157,371,768.50	468,120,245.88
Холбооны суваг ашигласны зардал	62,068,709.50	71,230,276.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	768,500.00	900,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	329,350.00	185,640.00
Банкны үйлчилгээний шимтгэл	6,341,896.17	5,639,433.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,159,296,296.35	2,701,155,061.14
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	30,732,539.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	17,009,140.00	29,847,500.00
Элэгдлийн зардал	3,111,554,617.35	2,671,307,561.14
<u>УРСГАЛ , ШИЛЖҮҮЛЭГ</u>	113,708,581.01	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	113,708,581.01	-
<u>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</u>	2,730,121.00	-
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,730,121.00	-
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (III)</u>	5,394,901,233.55	5,644,476,718.24
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</u>	(2,896,391,529.91)	(2,708,783,921.22)
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</u>		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз(бодит)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарц	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</u>	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(2,896,391,529.91)	(2,708,783,921.22)

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,572,697.78	238,016,306.98
3	Өмчийн орлого	252,205,697.78	237,671,306.98
4	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	252,205,697.78	237,671,306.98
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	252,205,697.78	231,817,306.98
6	Бусад орлого	-	5,854,000.00
	Нэр данс зөрүүтэй орлого	367,000.00	345,000.00
7	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,896,975,045.69	3,184,592,839.55
8	<i>Улсын төсвөөс</i>	1,621,553,848.52	1,762,675,900.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,621,553,848.52	1,762,675,900.00
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,275,421,197.17	1,421,916,939.55
11	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,244,688,658.27	1,421,916,939.55
12	Төсвийн урамшуулал	30,732,538.90	-
13	<u>ҮЙЛ АЖИЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(II)</u>	3,149,547,743.47	3,422,609,146.53
14	<u>НИЙТ ЗАРЛАГА</u>	3,149,514,743.47	3,414,417,686.53
15	<u>УРСГАЛ ЗАРЛАГА</u>	3,149,514,743.47	3,414,417,686.53
16	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	3,149,514,743.47	3,414,417,686.53
17	<u>ҮЙЛ АЖИЛАГААНЫ ЗАРДАЛ</u>		
18	<u>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	1,242,795,441.52	1,332,890,349.74
19	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,119,960,056.01	1,201,553,092.07
20	Цалин	1,085,786,056.01	905,361,299.52
21	Унаа хоолны хөнгөлөлт	34,174,000.00	29,523,000.00
	Гэрээт ажлын хөлс	-	266,668,792.55
22	Нийгмийн хамгааллын шимтгэл	122,835,385.51	131,337,257.67
23	Тэтгэврийн шимтгэл	77,948,343.25	83,275,133.98
24	Тэтгэмжийн шимтгэл	5,610,880.28	6,007,765.46
25	ҮОМШӨвчний шимтгэл	11,221,760.56	12,015,530.92
26	Ажилгүйдлийн шимтгэл	5,610,880.28	6,007,765.46
27	Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,443,521.13	24,031,061.84
28	<u>УРСГАЛ ЗАРДАЛ</u>	1,906,719,301.95	2,081,527,336.79
29	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,183,881.01	367,969,625.16
30	Гэрэл цахилгааны зардал	189,732,129.92	242,161,750.32
31	Түлш, халаалтын зардал	62,852,500.00	51,793,039.06
32	Цэвэр, бохир усны зардал	7,136,589.80	3,756,710.62
33	Байрны түрээсийн	36,462,661.29	70,258,125.16
34	Хангамж бараа материалын зардал	222,896,421.43	268,945,555.24
35	Бичиг хэргийн материал	143,480,865.00	141,079,876.00
36	Тээвэр, шатахууны зардал	54,689,434.00	94,094,400.00
37	Шуудан холбооны зардал	22,554,863.43	28,581,380.24
38	Ном, хэвлэлийн зардал	18,000.00	-
39	БҮТЭЗ	1,808,259.00	4,467,047.00
40	Хог хаягдал устгах	345,000.00	722,852.00
41	Эд хогшил урсгал засварын зардал	164,205,664.00	303,302,913.00
42	Багаж хэрэгсэл	1,075,000.00	35,021,660.00
	Тавилга		3,549,700.00
43	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	600,000.00	2,013,000.00
44	Урсгал засварын зардал	162,530,664.00	262,718,553.00

45	Томилолт зочны зардал	20,104,894.00	15,955,000.00
46	Дотоод томилолтын зардал	-	10,755,000.00
47	Гадаад томилолтын зардал	20,104,894.00	5,200,000.00
48	Гадаад зочны зардал	-	-
49	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил , үйлчилгээний төлбөр	258,032,769.50	622,228,113.88
50	Холбооны суваг ашигласны зардал	59,166,218.50	100,775,958.00
51	Аудитын үйлчилгээний зардал	4,000,000.00	4,500,000.00
52	Тээврийн хэрэгслийн оношлогоо	900,000.00	900,000.00
53	Тээврийн хэрэгслийн татвар	164,350.00	185,640.00
54	Мэдээлэл технологийн үйлчилгээний	189,830,346.00	513,579,591.88
55	Газрын төлбөр	-	1,667,424.00
56	Төлбөр хураамж, жижиг татварууд	-	-
57	Банкны үйлчилгээний шимтгэл	3,971,855.00	619,500.00
58	Бараа үйлчилгээний бусад зардал	155,684,350.00	29,847,500.00
59	Бараа үйлчилгээний бусад зардал	101,079,889.00	-
60	Хичээл , үйлдвэрлэлийн дадлага	23,871,922.00	29,847,500.00
61	Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	30,732,539.00	-
62	ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	776,981,662.01	473,278,629.51
63	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
64	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	113,708,581.01	152,261,229.51
	Урсгал шилжүүлэг	663,273,081.00	321,017,400.00
65	НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	12,629,660.00	-
66	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,629,660.00	-
67	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	3,149,514,743.47	3,414,417,686.53
68	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	33,000.00	8,191,460.00
69	Хөрөнгийн орлого	-	-
70	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
71	Бусад хөрөнгийн борлуулалтын орлого	-	-
72	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
73	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	-
74	Хөрөнгийн бусад зардал	-	-
75	Урсгал зардлаас хөрөнгө худалдан авсан	-	-
76	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	-	-
77	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
78	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
79	Авсан зээл	-	-
80	Төлсөн зээл	-	-
81	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
82	Валютын ханшийн зөрүү	-	-
83	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	33,000.00	8,191,460.00
84	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,000.00
85	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,000.00	8,224,460.00

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын оролцооны нийт дүн
1	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	-	5,088,021,895.33	11,802,654,960.66
1.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
1.2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
1.3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
1.4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
1.5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
2	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,896,391,529.91)	(2,896,391,529.91)
2.1	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	-	2,191,630,365.42	8,906,263,430.75
2.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
2.3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
2.4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
2.5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
2.6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
2.7	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,708,783,921.22)	(2,708,783,921.22)
3	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	-	(517,153,555.80)	6,197,479,509.53

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТҮГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31

Бүртгэлийн н дансны код	Бүртгэлийн дансны нэр	
А	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ОРЛОГО / ҮАО+ХҮАО+СҮАО/	3,422,609,146.53
	Өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын орлогозарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгө	33,000.00
	Хасах нь:	-
120002	Хүүгийн орлого	-
120009	Бусад орлого	-
120013	Борлуулалтын орлого /ТӨҮГ/	-
120016	Буцаан авсан татвар /ТӨҮГ/	-
145007	Зээл	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,199,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	321,017,400.00
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-
122002	Хандив тусламж	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,261,228.51
131103	Засаг даргын нөөц сангаас /Бу, За, Ор, Өв, Сэ, Хө аймгийн ГХБХБГ/	
130303	Бусад	-
Б	Тохируулсан орлогын дүн	479,477,628.51
В	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ОРЛОГЫН ДҮН / А-Б/	2,943,131,518.02
Г	Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлага /ҮАЗ+ХҮАЗ+СҮАЗ/	3,414,417,686.53
	Зарлагын тохируулга	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	619,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-
213209	Нэг удаагийн тэтгэвэр тэтгэмж	-
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ төсөвт байгууллага/	152,261,229.51
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-
213403	Төвлөрүүлсэн орлого аймаг	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	321,017,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад	
Д	Тохируулсан зарлагын дүн	473,898,129.51
	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАРЛАГЫН ДҮН / Г-Д/	2,940,519,557.02
	Тохируулгын орлого, зарлагын зөрүү / Б-Д/	5,612,499.00